



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу зарцуулбал зохих төлбөрийн орлогын 23.5 хувийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд төлөвлөж, баталсан байна.

АУДИТЫН СЭДЭВ: БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: СЭА-2023/30-17-ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Сүхбаатар сум	Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Утас: 70363040	
2023 он	Аудитын менежер Б.Батмөнх	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Утас: 70363036	
	Ахлах аудитор С.Баасансүрэн	Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com
	Утас: 70363036	
	Аудитор Ж.Цогт	Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn
	Аудитор Д.Чулуунцэцэг	Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
Ерөнхий мэдээлэл	4
А бүлэг: Сумдын төсвийн татварын орлогын дийлэнх хэсгийг буюу дунджаар 64.1 хувийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар зохицуулснаас сумдын суурь зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр хүрэлцэхгүй байх эрсдэлтэй байна.	5
А.1. 2022 оны байдлаар аймгийн хөгжлийн бодлогын баримт бичигт дэвшүүлсэн “Ногоон хөгжил”-ийн зорилт, арга хэмжээний дунд хугацааны хэрэгжилт 99.3 хувьтай, богино хугацааны хэрэгжилт 92.5 хувьтай тайлагнагдсан байна.	5
А.2. Аймгийн Засаг дарга нь өөрийн харьяа төсөв захирагч нарын 2021, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, хэрэгжилтийг үнэлж, дүгнэсэн байна.	8
Б бүлэг: БНАТ-ийн орлогоос хуулийн дагуу зарцуулбал зохих доод хувь хэмжээгээр тооцож, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөж, батлаагүй байна.	11
Б.1 Зарим сумд “Ойн дагалт баялаг ашигласны төлбөрийн орлого”-ыг байгалийн ургамлын нөөц ашигласны орлогын дансанд төвлөрүүлсэн байна.	11
Б.2 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хууль, журамд заасан хувь хэмжээгээр тооцон санхүүжүүлэхгүй байна.	15
В бүлэг: Шат, шатны ИТХ болон холбогдох бусад байгууллагаас Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт, шалгалт хангалтгүй байна.	18
В.1 Төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүйгээс БНАТ-ийн мэдээллүүд зөрүүтэй тайлагнагдсан байна.	18
В.2 Аймгийн ИТХ болон нийт сумдын 70.5 хувь нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт огт хийгээгүй байна.	20
Илрүүлсэн зөрчил	21
Дүгнэлт	22
Зөвлөмж	22
Ирүүлсэн санал, тайлбар	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОАЖ	Байгаль орчин, аялал жуулчлал
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
УИХ	Улсын Их Хурал
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

Хүснэгтийн товчлол

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Ойн менежментийн төлөвлөгөө байгуулаагүй нөхөрлөлийн нэрс	7
Хүснэгт 2	БОАЖ-ын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилт	9
Хүснэгт 3	Аймгийн БОАЖГ-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт	10
Хүснэгт 4	Төрөл зүйлийн дээд хэмжээг тогтоосон шийдвэр	12
Хүснэгт 5	Аймгийн БОАЖГ нь төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэх харилцаа	12
Хүснэгт 6	Байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл бүхий ААН-ийн тоо	13
Хүснэгт 7	БОАЖГ-аас хүргүүлсэн төсвийн санал болон батлагдсан төсөв	14
Хүснэгт 8	Байгалийн ургамал ашигласны төлбөрийн дансанл төвлөрүүлсэн ойн дагалт баялагийн судалгаа	15
Хүснэгт 9	БНАТ-ийн орлогын төлөвлөлт	16
Хүснэгт 10	БНАТ-ийн төрлөөрх төлөвлөлт	16
Хүснэгт 11	Мэдээллийн санд оруулсан БНАТ-ийн мэдээлэл	18
Хүснэгт 12	Төрийн байгууллагуудын мэдээлсэн БНАТ-ийн орлого, гүйцэтгэлийн мэдээ	19
Хүснэгт 13	Нутгийн өөрөө байгууллагаас хийсэн хяналт, шалгалт	20

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: ➤ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх, ➤ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжсэн эсэх, ➤ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авсан эсэх.
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд төрөөс баримталж байгаа бодлогын баримт бичиг, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын 2021-2023 оны бүрдүүлэлт, зарцуулалтыг аймгийн ИТХ, Засаг дарга, ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, ГХБХБГ, Татварын хэлтэс, сум дундын Ойн ангиуд болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнуудыг хамрууллаа.
Аудитын арга зүй:	Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4000, 4001, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын тулгуур зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аймгийн ИТХ, Засаг дарга, ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, ХШҮХ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, ГХБХБГ, Татварын хэлтэс, сум дундын Ойн ангиудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, нэгтгэх, харьцуулах, холбоотой баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

	• Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, • Байгаль орчныг хамгаалах тухай хууль, • Ойн тухай хууль, • Байгалийн ургамлын тухай хууль, • Амьтны тухай хууль, • Усны тухай хууль, • Газрын тухай хууль, • Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, • Төсвийн тухай хууль, • Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, • Хууль тогтоомжийн тухай хууль, • УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан <i>“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”</i>, • УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан <i>“Алсын хараа- 2050”</i> Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, • Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, • Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан <i>“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”</i>, • Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан <i>“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”</i>, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор баталсан <i>“Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”</i> болон бусад холбогдох эрх зүйн актууд.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Ж.Цогт, Д.Чулуунцэцэг нар 2023 оны 5 дугаар сарын 05-ны өдрөөс 6 дугаар сарын 19-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.
Ерөнхий мэдээлэл:	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогод 2021 онд 8,641.1 сая төгрөгийн орлогыг төлөвлөж, гүйцэтгэлээр 59.6 хувиар давуулан 13,789.8 сая төгрөгийг, 2022 онд 9,928.5 сая төгрөгийн орлогыг төлөвлөж, гүйцэтгэлээр 73.1 хувиар давуулан 17,191.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Тайлант онуудад байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний зардалд нийт 15,736.7 сая төгрөгийг хуулийн дагуу зарцуулах ёстойгоос 3,697.1 сая төгрөг буюу 23.5 хувийг зарцуулахаар баталсан байна.

Бүлэг А

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх.

Сумдын төсвийн татварын орлогын дийлэнх хэсгийг буюу дунджаар 64.1 хувийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар зохицуулснаас сумдын суурь зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр хүрэлцэхгүй байх эрсдэлтэй байна.

А.1 Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж байна уу?

2022 оны байдлаар аймгийн хөгжлийн бодлогын баримт бичигт дэвшүүлсэн “Ногоон хөгжил”-ийн зорилт, арга хэмжээний дунд хугацааны хэрэгжилт 99.3 хувьтай, богино хугацааны хэрэгжилт 92.5 хувьтай тайлагнагдсан байна.

А.1.1 2012 онд баталсан Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1¹-д БНАТ-ийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн жилд зарцуулах хувь хэмжээний доод хязгаарыг байгалийн нөөцийн төрөл тус бүрээр 15-85 хувиар тогтоож, Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.3-т “Энэ журмын 3.1-д заасан нөхцөл, хязгаарыг хангаагүй тохиолдолд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоор орон нутгийн төсвийн суурь зарлагыг санхүүжүүлэхгүй” гэж заасан байдаг.

А.1.2 Нөгөө талаас Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.4-т сумын төсвийн татварын орлого нь ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны, байгалийн ургамал ашигласны, хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны, агнуурын нөөц болон газрын нөөцийн төлбөрийн орлогоос бүрдэхээр, тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30², Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын 1.2.1³ дэх заалтуудад орон нутгийн төсвийн суурь зарлага гэх ойлголтыг тодорхойлсон байдаг.

А.1.3 Дээрх хууль, эрх зүйн заалтуудаас харахад сумдын төсвийн татварын орлогын дийлэнх хэсгийг буюу дунджаар / байгалийн дагалдах баялаг ихтэй Мандал,

¹ Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно: 1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого 15 хувь 2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 50 хувь 3. Газрын нөөцийн төлбөрийн орлого 15 хувь 4. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 85 хувь 5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 35 хувь.

² Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 4.1.30. орон нутгийн төсвийн суурь зарлага гэж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын болон орон нутгийн чиг үүрэг, төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлагын нийлбэрийг

³ Энэ аргачлалд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 1.2.1. орон нутгийн төсвийн суурь зарлага гэж Төсвийн тухай хуулийн 4.1.30-д заасныг

Ерөө, Хүдэр сумдын дундажаар тооцсон / 61.4хувийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар зохицуулснаас сумдын суурь зарлага буюу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын болон орон нутгийн чиг үүрэг, төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр хүрэлцэхгүй байх эрсдэлтэй байна.

A.1.4 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4⁴-т заасны дагуу УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталж, “Ногоон хөгжил”-ийн зорилтыг дэвшүүлсэн байна.

A.1.5 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.7⁵-д заасны дагуу аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 12 дугаар тогтоолоор аймгийн хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг “Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг баталсан бөгөөд “Ногоон хөгжил”-ийн 3 зорилт, 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

A.1.6 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.9⁶-д заасны дагуу аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор “Сэлэнгэ аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”, 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Сэлэнгэ аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г тус тус баталж, “Ногоон хөгжил”-ийн богино хугацааны зорилт, арга хэмжээг тусгасан байна.

A.1.7 Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.3⁷-т заасны дагуу аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь дээрх бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дараах байдлаар үнэлж, дүгнэсэн байна. Үүнийг тодруулбал:

- Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний “Ногоон хөгжил”-ийн зорилт, арга хэмжээний 2021 оны хэрэгжилтийг 77.8 хувиар, 2022 оны хэрэгжилтийг 92.5 хувиар үнэлсэн,
- Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн “Ногоон хөгжил”-ийн зорилт, арга хэмжээний 2021 оны хэрэгжилтийг 64.6 хувиар, 2022 оны хэрэгжилтийг 99.3 хувиар үнэлж, дүгнэсэн.

A.1.8 Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,

⁴ “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” гэж ... , байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, хүний хөгжлийг хангах, эдийн засаг, нийгэм, засаглалын хөгжлийг ахисан түвшинд хүргэхэд чиглэсэн урт хугацааны зорилго, зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийг тусгасан баримт бичиг.

⁵ Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсын таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна.

⁶ Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна.

⁷ Захиргааны байгууллага нь бодлогын баримт бичигт тодорхойлсон төлөвлөгөөний дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу энэ журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалаар үнэлнэ.

үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 7.7.3⁸-т заасны дагуу аймгийн 2021, 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг аймгийн ИТХ-д танилцуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.

А.1.9 Дээрхээс үзэхэд Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд хугацааны баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хүрээнд аймгийн хөгжлийн бодлогын дунд, богино хугацааны баримт бичигт "Ногоон хөгжил"-ийн зорилтыг тусгаж, хэрэгжүүлснээр тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэж байна.

А.1.10 Ойн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.2⁹-т заасны дагуу БОАЖЯ-ны дэргэдэх орон тооны бус "Ойн нөөцийн мэргэжлийн зөвлөл"-ийн 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хурлаар 5 зорилт, 17 арга хэмжээ бүхий "Сэлэнгэ аймгийн Ойн менежментийн төлөвлөгөө 2021-2025"-г баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

А.1.11 Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.10¹⁰-д заасны дагуу аймгийн Засаг дарга нь ой бүхий 10 сумын "Ойн менежментийн төлөвлөгөө"-г баталж, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

А.1.12 Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.9¹¹-д заасны дагуу аймгийн БОАЖГ-ын дарга нь ойн санг гэрээгээр эзэмшигч 108 нөхөрлөл, 92 аж ахуйн нэгж, байгууллагын "Ойн менежментийн төлөвлөгөө"-г баталж, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

А.1.13 Харин 6 сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 58 нөхөрлөл "Ойн менежментийн төлөвлөгөө"-г боловсруулж аймгийн БОАЖГ-ын даргаар батлуулаагүй байгаа нь Ойн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3¹², 21 дүгээр зүйлийн 21.1¹³ дэх заалтыг зөрчсөн байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

Д/д	Ой бүхий сумын нэр	"Ойн менежментийн төлөвлөгөө"-г батлуулаагүй нөхөрлөлийн	
		Тоо	Нэрс
1	Ерөө	19	Баялаг, Баянхангай, Шаазгайт, Хангай, Шинэстэй оргил, Улаанбулаг, Хайрхан хөндий, Гурвангол, Баруунбулаг, Тэмүүлэн, Тангуй, Их хөвч, Хөвч, Бугант хангай, Хангайн бугант, Элбэг, Мөнх төгөл, ТЭБА гацуур, Баянжин.

⁸ Орон нутгийн захиргааны байгууллага аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг аймаг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. ...

⁹ Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ойг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.3.2.улсын ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих.

¹⁰ Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 17.2.10.ой бүхий сум, дүүргийн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих.

¹¹ Аймаг, нийслэлийн Байгаль орчны газар нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 17.3.9.ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих.

¹² Ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь ойн санг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй үндэслэлтэйгээр тусгасан ойн менежментийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулна.

¹³ Ойн нөхөрлөл нь энэ хуулийн 4.9, 9.3-т заасны дагуу ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн менежментийн төлөвлөгөөтэй байна.

2	Баруунбүрэн	12	Далд, Бумбат хангай, Байгалийн хишиг, Түвшинбүрэн, Ногоон сан, Бүрэн төгөл, Шар хоолой, Шувуутын шугуй, Шувуутын төгөл, Ар булаг, Бүрэн тоонч, Наран.
3	Баянгол	9	Сэвсүүл, Өндөр бургас, Манхтай, Баян эрхэт, Нарангийн гол, Цахар гурван булаг, Өгөөмөр хараа, Цагаан чулуут, Гурвансайхан.
4	Сант	4	Алтансүмбэр, Хан хушаат, Гүнсэлдэй, Ноёны бууц
5	Хушаат	7	Тарвагатай, Чин хүслэн, Тогос хайрхан, Могойт, Газар эх, Баянзүрх хайрхан, Сэвд могой.
6	Хүдэр	7	Хэрцийн өндөр, Хүдэр хануй, Их тайга, Шанд, Дөлгөөний өвөр, Хөвчийн хангай, Оргил.
	Нийт	58	

A.1.14 Амьтны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4¹⁴-т заасны дагуу агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллага “Агнуур судлалын нийгэмлэг” ТББ нь 11 зорилт, 39 арга хэмжээ бүхий “Сэлэнгэ аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга баталсан байна.

A.1.15 Дээрх менежментийг төлөвлөгөөг 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 01 дүгээр актаар аймгийн БОАЖГ-т хүлээлгэж өгсөн бөгөөд агнуур зохион байгуулалт буюу ахуйн зориулалтаар агнах, барих ажлыг гүйцэтгэж ирсэн байна.

A.1.16 Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1¹⁵-д заасны дагуу аймгийн ИТХ-ын 2008 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 35 дугаар тогтоолоор “Сэлэнгэ аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г баталж, 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 42 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан байна.

A.1.17 Сумдын хувьд сумын Засаг даргын өргөн мэдүүлсэн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг сумын ИТХ-ын тогтоолоор баталсныг мөрдөн ажиллаж байна.

A.1.18 Дээрхээс үзэхэд ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөлийн 35 хувь нь “Ойн менежментийн төлөвлөгөө”-г батлуулаагүй байна.

A.2 Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн үү?

Аймгийн Засаг дарга нь өөрийн харьяа төсөв захирагч нарын 2021, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, хэрэгжилтийг үнэлж, дүгнэсэн байна.

¹⁴ Агнуурын нөөцийг хамгаалах зорилго бүхий мэргэжлийн байгууллага агнуурын нөөцийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 21.4.1. агнуурын нөөц, түүний тооллого бүртгэл, агнуур зохион байгуулалтын ажлыг улс, орон нутгийн болон иргэн, хуулийн этгээдийн захилга, хөрөнгөөр гүйцэтгэх, тэдгээрийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулах.

¹⁵ Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын харилцааны талаар дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 20.1.2. тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухай жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах.

A.2.1 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5¹⁶, Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1¹⁷-д заасны дагуу БОАЖ-ын сайд аймгийн Засаг даргатай жил бүр хамтран ажиллах гэрээ байгуулж, байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусган, хэрэгжилтийг дүгнэж ирсэн байна.

A.2.2 Аймгийн Засаг дарга БОАЖ-ын сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр 2021 онд 9 зорилт, 47 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 88.0 хувиар үнэлсэн бол байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбоотой 26 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 96.5 хувиар үнэлж, дүгнэсэн байна.

A.2.3 Харин 2022 онд 7 зорилт, 60 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 95.1 хувиар үнэлсэн бол байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбоотой 33 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 95.8 хувиар үнэлж, дүгнэсэн байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2

БОАЖ-ын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилт	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний		Үүнээс: БНАТ, түүнтэй холбогдох харилцааг тусгасан	
	Тоо	Хэрэгжилтийн хувь	Тоо	Хэрэгжилтийн хувь
2021 он	47	88.0	26	96.5
2022 он	60	95.1	33	95.8

Эх сурвалж: БОАЖА-ны ХШҮДАХ-ийн 2021, 2022 онд хийсэн үнэлгээ

A.2.4 Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1¹⁸, 40.3¹⁹-т заасны дагуу аймгийн Засаг дарга БОАЖГ-ын даргатай тухайн жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусган, хэрэгжилтийг дүгнэж ирсэн байна.

A.2.5 Аймгийн Засаг дарга БОАЖГ-ын даргатай байгуулсан 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт, 41 арга хэмжээг төлөвлөж, аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь хэрэгжилтийг 67.6 хувиар үнэлсэн бол байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбоотой 20 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 76.0 хувиар үнэлж, дүгнэсэн байна.

A.2.6 Харин 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 32 арга хэмжээг төлөвлөж, аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь хэрэгжилтийг 86.0 хувиар үнэлсэн бол байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбоотой 20 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 90.0 хувиар үнэлж, дүгнэсэн байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

¹⁶ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар дараах төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлнэ: 27.5.10. байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, нөхөн сэргээлт.

¹⁷ Энэ хуулийн 14.1.6, 14.1.11-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь аймаг нийслэл, сум, дүүргийн Засаг даргатай энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг байгуулж болно.

¹⁸ Төсвийн шууд захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч нь харьяалах дээд шатныхаа төсвийн захирагчтай төсвийн жил эхлэхээс өмнө үр дүнгийн гэрээ байгуулна.

¹⁹ Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ.

Аймгийн БОАЖГ-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний		Үүнээс: БНАТ, түүнтэй холбогдох харилцааг тусгасан	
	Тоо	Хэрэгжилтийн хувь	Тоо	Хэрэгжилтийн хувь
2021 он	41	67.6	20	76.0
2022 он	32	86.0	26	90.0

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ийн 2021, 2022 онд хийсэн үнэлгээ

A.2.7 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5²⁰, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1²¹-д заасны дагуу аймгийн Засаг дарга сумын Засаг дарга нартай жил бүр хамтран ажиллах гэрээ байгуулж, байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусган, хэрэгжилтийг дүгнэж ирсэн байна.

A.2.8 Аймгийн Засаг дарга сумын Засаг дарга нартай 2021 онд байгуулсан хамтран ажиллах гэрээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр 12-22 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 41.8-92.0 хувиар үнэлсэн бол байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбоотой 5-7 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг дунджаар 20.0-98.3 хувиар үнэлж, дүгнэсэн байна.

A.2.9 Харин 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр 16-21 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 46.9-90.0 хувиар үнэлсэн бол байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбоотой 5-6 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 35.0-95.0 хувиар үнэлж, дүгнэсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-д харуулав/

A.2.10 Ойн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “...аймаг, суманд сум дундын болон сумын ойн анги /цаашид ойн анги гэх/ ажиллана.” гэж заасны дагуу Бэлчир, Ерөө, Орхон, Сэлэнгэ, Хараа гэсэн 5 бүсийн сум дундын Ойн анги болон Хүдэр сумын “Ой анги” ОНӨААТҮГ үйл ажиллагаа явуулж байна.

A.2.11 Дээрх сум дундын Ойн ангийн дарга нар нь 2021 онд Ковид-19 цар тахал гарч, зарим үйл ажиллагаа хязгаарлагдмал байсан гэх шалтгаанаар аймгийн Засаг даргаар гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө батлуулж, дүгнүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1²², 40.3²³ дахь заалтыг зөрчсөн байна.

A.2.12 Харин 2022 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр 14-43 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 84.9-91.5 хувиар үнэлсэн бол байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй

²⁰ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар дараах төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлнэ: 27.5.10. байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, нөхөн сэргээлт.

²¹ Энэ хуулийн 14.1.6, 14.1.11-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь аймаг нийслэл, сум, дүүргийн Засаг даргатай энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг байгуулж болно.

²² Төсвийн шууд захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч нь харьяалах дээд шатныхаа төсвийн захирагчтай төсвийн жил эхлэхээс өмнө үр дүнгийн гэрээ байгуулна.

²³ Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ.

холбоотой 4-8 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 87.3-92.3 хувиар үнэлж, дүгнэсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 2-т харуулав/

А.2.13 Харин Хүдэр сумын “Ой анги” ОНӨААТҮГ-ын дарга нь 2021, 2022 онуудад сумын Засаг даргатай зөвхөн “Хөдөлмөрийн гэрээ” байгуулж ажилласан бөгөөд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлуулж, дүгнүүлээгүй байна.

А.2.14 2023 онд тус үйлдвэрийн газрын дарга нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр 4 зорилт, 22 арга хэмжээ бүхий “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө”-г сумын Засаг даргаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

А.2.15 Дээрхээс үзэхэд аймгийн Засаг дарга нь өөрийн харьяа төсөв захирагч нарын 2021, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, хэрэгжилтийг үнэлж, дүгнэсэн байна.

Бүлэг Б

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжсэн эсэх.

БНАТ-ийн орлогоос хуулийн дагуу зарцуулбал зохих доод хувь хэмжээгээр тооцож, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөж, батлаагүй байна.

Б.1 Төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт хуулийн дагуу хэрэгжиж байна уу?

Зарим сумд “Ойн дагалт баялаг ашигласны төлбөрийн орлого”-ыг байгалийн ургамлын нөөц ашигласны орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Б.1.1 Аймгийн Засаг дарга нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2.2-т заасны дагуу нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний талаарх саналаа жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ гэж заасан.

Б.1.2 БОАЖЯ нь аймгаас ирүүлсэн саналыг хянан, ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг тогтоож, жил бүрийн 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ. Үүнийг үндэслэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор сум, дүүрэг тус бүрээр тогтооно гэж заасан байдаг.

Б.1.3 Аймгийн БОАЖГ нь сумдаас ирүүлсэн тухайн онд ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний талаарх саналыг үндэслэн боловсруулж, БОАЖЯ-нд БОАЖГ-ын даргын 2021 оны 07 дугаар 18-ны өдрийн 326 дугаар, 2022 оны 07

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт

дугаар 25-ны өдрийн 337 дугаар, 2023 оны 04 сарын 26-ны өдрийн 282 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн байна.

Б.1.4 БОАЖЯ нь аймгаас ирүүлсэн саналыг хянасны үндсэн дээр ашиглах байгалийн нөөцийн төрлийг тогтоож, аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4

№	Байгалийн нөөцийн нэр	Зөвшөөрсөн төрөл зүйлийн тоо хэмжээ			Ашиглахаар зөвшөөрөгдсөн төрөл зүйлийн нэр
		2021	2022	2023	
1	Байгалийн ургамал	21	22	0	Элбэг төрлийн ургамлууд
2	Ан амьтан	3	3	3	Саарал чоно, Бор гөрөөс, Зэрлэг гахай
3	Хэрэглээний мод, түлээ	7	7	7	Шинэс, нарс, хуш, хус, улиас, улиангар, бургас
4	Ойн дагалт баялаг	1	1	1	Хуш модны самар

Б.1.5 Аймгийн БОАЖГ нь төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэх харилцааг журмын дагуу хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнийг дараах хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал:

Хүснэгт 5

Д/д	Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцаа	
	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Байгалийн ургамлын нөөцийн ашиглах дээд хэмжээг тогтоох	БОАЖЯ нь Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтыг үндэслэн БОАЖС-ын 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/136 дугаар "Байгалийн ургамал ашиглах дээд хэмжээг батлах тухай", 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/190 дугаар "Байгалийн ургамал түүж бэлтгэх дээд хэмжээ тогтоох тухай" тушаалаар 2021 онд ашиглах ховор ургамлын зүйлийн тоог 7, элбэг ургамлын төрөл зүйлийн тоог 14-өөр, 2021 онд ашиглах ховор ургамлын зүйлийн тоог 7, элбэг ургамлын төрөл зүйлийн тоог 15-аар тогтоон ирүүлсэн боловч 2023 онд ашиглах байгалийн ургамал зүйлийн тоо, дээд хэмжээг баталсан тушаалыг ирүүлээгүй байна.
2	Ахуйн зориулалтаар агнах, барих ан амьтны дээд хэмжээг тогтоох	Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2 -т заасны дагуу аймгийн БОАЖГ нь ан агнуурын менежментийн төлөвлөгөөг 2019 онд боловсруулж, БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газраар батлуулсан мөрдөн ажиллаж байна. БОАЖЯ нь БОАЖС-ын 2021 оны А/701 дүгээр "2021 онд ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг тогтоох тухай", 2022 оны А/89 дүгээр "2022 онд ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг тогтоох тухай" тушаалаар 2021, 2022 онд агнах, барих ан амьтны саарал чоно, зэрлэг гахай, бор гөрөөс зэрэг 3 төрөл зүйлээр тогтоож ирүүлсэн байна. Дээрх тушаалын дагуу аймгийн БОАЖГ нь жил бүр ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны төрөл, тоо дээд хэмжээг агнуурын бүс нутаг бүхий сумдад хуваарилах саналыг боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэн ажилласан байна. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 -д заасны дагуу 2021-2023 онд агнах, барих амьтны төрөл, тоо хэмжээ болон ашиглах ойн дагалдах баялаг, ургамлын хэмжээг тодорхой бүс нутагт ашиглахыг хориглосон шийдвэр гаргаагүй байна.
3	Ойгоос бэлтгэх хэрэглээний мод, түлээ бэлтгэх дээд хэмжээг тогтоох	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалаар баталсан "Ойгоос мод бэлтгэх тухай журам"-ын 2.3 -т заасны дагуу аймгийн БОАЖГ нь БОАЖЯ-нд ойн сангаас бэлтгэх модны төрөл, ашиглах дээд хэмжээний 2021 оны саналыг БОАЖГ-ын даргын 2020 оны 1/311 дүгээр, 2022 оны саналыг 2021 оны 1/218 дугаар, 2023 оны саналыг 2022 оны 1/342 дугаар албан бичгээр тус тус хуулийн хугацаанд нь хүргүүлсэн байна. Дээрх саналыг үндэслэн БОАЖЯ-аас ойгоос бэлтгэх хэрэглээний мод, түлээг шинэс, нарс, хуш, хус, улиас, улиангар, бургас зэрэг 7 төрлөөр тогтоож БОАЖС-ын 2020 оны А/599 дүгээр "2021 оны ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай", 2021 оны А/217 дугаар "2022 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг тогтоох тухай" тушаалаар тус тус баталгаажуулан ирүүлсэн байна.
4	Ойн дагалт баялгийн ашиглах дээд хэмжээг тогтоох	Аймгийн Засаг дарга нь БОАЖЯ-нд БОАЖС-ын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/282 дугаар тушаалаар батлагдсан "Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам"-ын 2.4 -д заасны дагуу сумдын ойн сан дахь хуш модны самрын ургацын мэдээ, дүгнэлтийг үндэслэн тооцсон үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар ашиглах хуш модны самрын дээд хэмжээний саналаа хуулийн хугацаанд нь хүргүүлсэн байна. БОАЖС-ын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/282 дугаар тушаалаар батлагдсан "Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам"-ын 2.6 -д заасны дагуу БОАЖЯ нь БОАЖС-ын 2021 оны 02 дугаар сарын 02-ний өдрийн А/298 дугаар "Ойгоос хуш модны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох тухай", 2022 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн А/372 дүгээр "Ойгоос хуш модны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох тухай" тушаалаар үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар ашиглах самрын зориулалт болон дээд хэмжээг тус тус тогтоон баталгаажуулж ирүүлсэн байна.

Б.1.6 Дээрхээс үзэхэд байгалийн нөөцийн төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцаа журмын дагуу хэрэгжсэн байна.

Б.1.7 Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг

бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2.5²⁴-д, 2.6²⁵-д, 2.7²⁶-д заасны дагуу сумдын Засаг дарга нар нь өөрийн сумын төсөвт төвлөрүүлэх байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг БНАТ-1 маягтын дагуу боловсруулан байгаль орчныг хамгаалах төсөв, зардлын мэдээллийн eis.mn санд байршуулсан боловч Баруунбүрэн, Түшиг зэрэг сумд нь мэдээллээ байршуулаагүй байна.

Б.1.8 Аймгийн БОАЖГ нь аймгийн төсөвт төвлөрүүлэх байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг боловсруулж БНАТ-3 маягтын дагуу байгаль орчныг хамгаалах төсөв, зардлын мэдээллийн eis.mn санд байршуулсан байна.

Б.1.9 Аймаг сумын төсөвт төвлөрөх байгалийн нөөц ашигласны орлогын төлөвлөгөөг БНАТ-5 маягтын дагуу нэгтгэн боловсруулж аймгийн төсөвт тусгуулахаар БОАЖГ-ын даргын 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 338 дугаар албан бичгээр тус аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн байна.

Б.1.10 Сумын Засаг дарга нь Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7²⁷, БОАЖ-ын сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.9²⁸-д заасны дагуу ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөл, аж ахуйн нэгжийн ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн аймаг сумын ИТХ-аар баталсан хязгаарт багтаан мод бэлтгэх болон хуш модны самар бэлтгэх гэрээ байгуулан ажилласан байна. Гэрээ байгуулан ажилласан зөвшөөрөл бүхийн ашиглагчийн судалгааг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6

№	Байгалийн нөөцийн нэр	Ашиглагчийн тоо		Зөвшөөрөлтэй ашиглагчийн тоо	
		2021	2022	2021	2022
1	Байгалийн ургамал	30	40	30	40
2	Ан амьтан	74	160	74	160
3	Хэрэглээний мод, түлээ	122	97	122	97
4	Ойн дагалт баялаг /хуш модны самар/	28	16	28	16
	ДҮН	2275	2335	2275	2335

Б.1.11 Дээрхээс харахад сумдын Засаг дарга нь 2021 онд байгалийн нөөц ашиглах зөвшөөрөл бүхий 2275, 2022 онд 2335 /давхардсан тоогоор/ нөхөрлөл аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2²⁹-т заасны дагуу байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг

²⁴Сум, дүүргийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 23.8.4, 23.8.6, 23.8.7, 23.8.9, 23.8.14-т заасан орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-1 маягтын дагуу жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ

²⁵Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасан орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-3 маягтын дагуу жил бүрийн 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор боловсруулна

²⁶Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага энэ журмын 2.5, 2.6-д заасан нийт орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-5 маягтын дагуу нэгтгэж, аймаг, нийслэлийн төсвийн саналд тусгуулахаар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор тухайн шатны Засаг даргад хүргүүлнэ

²⁷ Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн сумын ИТХ-аас тогтоосон хязгаарт багтаан мод бэлтгэх шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих, хэрэгжилтийг хангуулж ажиллах.

²⁸ Үйлдвэрлэлийн зориулалтаар нөөц ашиглах ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагатай энэ журмын 2.2, 2.6 дахь хэсэгт заасан дээд хязгаарт багтаан сумын Засаг дарга гэрээ байгуулна.

²⁹Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг хууль тогтоомжийн дагуу олгох

хууль тогтоомжийн олгож, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3³⁰-т заасны дагуу төлбөрийн нэхэмжлэлийг үүсгэсэн байна.

Б.1.12 Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст БОАЖГ болон ГХБХБГ-аас ирүүлсэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний саналыг үндэслэн төлбөрийн орлогыг төлөвлөн батлуулсан байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7

№	Байгалийн нөөцийн нэр	БОАЖГ болон ГХБХБГ-аас хүргүүлсэн санал			Батлагдсан төсөв			Зөрүү		
		2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023
1	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	988.4	20.0	69.2	988.7	232.5	108.4	(0.3)	(212.5)	(39.2)
2	Ан амьтан агнасны төлбөр	19.3	19.6	9.5	19.3	19.2	9.0	-	0.4	0.5
3	Ойн нөөц ашигласны төлбөр	3,131.5	2,001.8	1,432.7	3,131.5	1,605.5	1,598.3	-	396.3	(165.6)
4	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай усны нөөц ашигласны төлбөр	650.0	1,585.2	900.0	800.0	900.0	1,000.0	(150.0)	685.2	(100.0)
5	Унд ахуйн зориулалттай усны нөөц ашигласны төлбөр	5.0	6.0	11.0	5.0	6.0	12.2	-	-	(1.2)
6	Газрын төлбөр	1,741.9	1,898.1	1,950.0	1,089.7	2,017.2	1,888.1	652.2	(119.1)	61.9
Дүн		6,536.1	5,530.7	4,372.4	6,034.2	4,780.4	4,616.0	501.9	750.3	(243.6)

Б.1.13 Дээрхээс үзэхэд аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг цахим сангийн мэдээлэл болон анхан шатны нэгжээс ирүүлсэн тооцоонд үндэслэн төлөвлөж аймаг, сумдын ИТХ-аар батлуулсан байна.

Б.1.14 ИТХ-ын тогтоолыг үндэслэн сумын Засаг даргатай хуш модны самар бэлтгэх гэрээ байгуулан ажиллаж байгаа нөхөрлөл аж ахуйн нэгжүүд нь гэрээний дагуу самар бэлтгэх эрхийн бичгийн орлогыг урьдчилан төвлөрүүлсэн бөгөөд БОАЖ-ын сайдын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/282 дугаар тушаалаар батлагдсан “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.16³¹, 3.17³²-д заасан хугацаанд бэлтгээгүйгээс 2021 онд Мандал сумын төрийн сангийн дансанд 268.0 сая төгрөг илүү төвлөрсөн байна.

Б.1.15 Мандал сумын Ойн анги нь сумын орон нутгийн төсөвт тухай бүр төвлөрөх 2021 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 175.1 сая төгрөгийг сум дундын Ойн ангийн нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн сарын эцэст орон нутгийн орлогын дансанд татан төвлөрүүлсэн байна.

Б.1.16 Аудитын явцад 2021, 2022, 2023 оны байгалийн ургамал ашигласны эрхийн бичиг, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны эрхийн бичиг, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх хуш модны самрын эрхийн бичиг, ахуйн зориулалтаар агнах, барих амьтны зөвшөөрлийн эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ зэргийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 9, 11, 12 дугаар зүйлд заасны дагуу байгалийн ургамал, ойн нөөц, ан амьтны нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт болон төрийн сангийн орлогын хуулга, төлбөр

³⁰Сум дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан байгалийн баялгийн нөөц ашиглах зөвшөөрөл бүхий иргэн аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 10 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ.

³¹Нөөцийг ашиглах зориулалт, хэмжээнээс хамаарч нэг удаагийн эрхийн бичгийг иргэнд 10 хүртэл хоног, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад 30 хүртэл хоногийн хугацаатай олгоно.

³²Байгалийн хүчин зүйлийн улмаас нөөцийг бэлтгэж амжаагүй бол тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч нэг удаа иргэнд 5 хүртэл хоног, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад 10 хүртэл хоногийн хугацаагаар сунгаж болно.

тушаасан баримттай тулган баталгаажуулахад Хараа, Сэлэнгэ, Орхон бүсийн сум дундын Ойн ангиуд болон Хүдэр сумын “Ойн анги” ОНӨААТҮГ нь ойн дагалт баялаг хуш модны самрын эрхийн бичгийн орлого болох нийт 6,918.0 сая төгрөгийг ургамлын нөөц ашигласны орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Б.1.17 Энэ нь Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12-т “Ойн дагалт баялаг гэж самар, эмийн болон хүнс, тэжээл зэрэг ойгоос авч ашиглаж байгаа аливаа баялгийн нөөцийг” гэж заасныг зөрчсөн байна. Үүнийг дараах хүснэгтээр дэлгэрэнгүйгээр харуулбал:

Хүснэгт 8

№	Ой ангийн нэр	Х/н	2021 он		2022 он		Нийт дүн	
			тоо хэмжээ	мөнгөн дүн	тоо хэмжээ	мөнгөн дүн	тоо хэмжээ	мөнгөн дүн
1	Мандал сум	кг	1,095,175	1,144.3	886,524	1,242.1	1,981,699	2,386.4
2	Хүдэр сум	кг	1,898,733	1,506.5	1,586,286	2,178.8	3,485,019	3,685.3
3	Цагааннур	кг	4,426	5.3	343,840	479.1	348,266	484.5
4	Баруунбүрэн	кг	-	-	258,440	361.8	258,440	361.8
	дүн		2,998,334	2,656.2	3,075,090	4,261.9	6,073,424	6,918.0

Б.1.18 Сум дундын Ойн ангиуд нь ойн дагалдах баялгийн нөөц болох хуш модны самрын эрхийн бичгийн төлбөрийн орлогыг байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогод төвлөрүүлснээс шалтгаалан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл бодитой бус тайлагнагдаж төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал бодитой төлөвлөгдөхгүй байх эрсдэлийг үүсгэж байгаа тул хуш модны самрын эрхийн бичгийн орлогыг ойн нөөц ашигласны төлбөрийн орлогод төвлөрүүлж байх шаардлагатай байна.

Б.1.19 Аймгийн Татварын хэлтэс нь Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7³³-д заасны дагуу Сав газрын захиргаанаас ус ашиглагч аж ахуйн нэгжүүдэд ногдуулсан усыг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласны болон бохирдуулсны усны төлбөрийн 23.9 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүйгээс татварын өр үүсгэсэн байна.

Б.1.20 Цаашид ус ашигласны төлбөрийн орлогыг тухай бүр төсөвт төвлөрүүлэн татварын өр үүсгэхгүй байх шаардлагатай байна.

Б.2 Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт хуулийн дагуу хэрэгжиж байна уу?

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хууль, журамд заасан хувь хэмжээгээр тооцон санхүүжүүлэхгүй байна.

Б.2.1 Аймгийн БОАЖГ нь 2021 онд 1,450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 30, 2022 онд 3,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 45, 2023 онд 3,850.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35 төсөл, арга хэмжээ зэрэг нийт 8,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 110

³³ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулах үндэслэлийг тодорхойлох;

арга хэмжээг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Б.2.2 Дээрх төлөвлөгөөг аймгийн Засаг дарга 2-3 дахин бууруулан аймгийн ИТХ-д өргөн мэдүүлж, батлуулан зөрүүг аймаг, сумдын суурь зарлагыг санхүүжүүлэхэд зарцуулж байна.

Б.2.3 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, сум, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална” гэж заасан байдаг.

Б.2.4 2021-2023 онуудад байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний зардалд нийт 15,736.7 сая төгрөгийг хуулийн дагуу зарцуулах ёстойгоос 3,697.1 сая төгрөг буюу 23.5 хувийг л зарцуулахаар баталсан байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 9

Тайлант он	орлогын төлөвлөгөө			Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд					
	өмнөх оны давсан орлого	тайлант оны төлөвлөгөө	Нийт орлого	Хуулийн дагуу зарцуулбал зохих доод хэмжээ	Аймгийн БОАЖГ-аас өгсөн санал	ИТХ-ын баталсан зардал	төлбөрийн орлогын эзлэх хувь	хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний тоо
2021 он	2,606.9	6,034.2	8,641.1	4,961.2	1,450.0	572.6	11.5%	22	22
2022 он	5,148.1	4,780.4	9,928.5	5,042.3	3,200.0	1,460.0	29.0%	33	33
2023 он	7,252.5	4,616.0	11,868.5	5,733.3	3,850.0	1,664.5	29.0%	24	24
Нийт	15,007.5	15,430.6	30,438.1	15,736.7	8,500.0	3,697.1	23.5%	79	79

Б.2.5 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно” гэж заасны дагуу тогтоож арга хэмжээг ИТХ-аар батлуулан, хэрэгжүүлэх ёстой.

Хүснэгт 10

БНАТ-ийн төрөл	Нийт орлого	Зарцуулах хувь хэмжээ	Хуулийн дагуу зарцуулбал зохих доод хэмжээ	ИТХ-ын баталсан зардал	Төлбөрийн орлогын эзлэх хувь
Ойн нөөц	14,698.8	85	12,494.0	2,743.4	19
Ан амьтны нөөц	49.8	50	24.9	125.0	251
Усны нөөц	4,322.0	35	1,512.7	748.7	17
Ургамлын нөөц	4,807.7	15	721.2	80.0	2
Газрын нөөц	6,559.8	15	984.0	-	0
Нийт	30,438.1		15,736.7	3,697.1	

Б.2.6 Дээрх хүснэгтээс харахад байгалийн нөөцөөс олсон орлогоос ойн нөөцөд 19.0 хувийг, ан амьтны нөөцөд 251.0 хувийг, усны нөөцөд 17.0 хувийг, ургамлын нөөцөд 2.0 хувийг зарцуулсан бол газрын нөөцийг нөхөн сэргээх чиглэлээр арга хэмжээ төлөвлөөгүй байна.

Б.2.7 Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан *“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”*-ын 3.12³⁴-т заасны дагуу аймгийн БОАЖГ-аас давсан орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар гүйцэтгэх арга хэмжээний саналыг 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 254 дүгээр албан бичгээр аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Б.2.8 Гэвч аймгийн Засаг даргаас 2023 оны төсөвт өмнөх оны давсан орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар гүйцэтгэх арга хэмжээг нэмж батлуулах саналыг аймгийн ИТХ-д өргөн мэдүүлж, батлуулаагүй буюу мөн л аймаг, сумдын суурь зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, батлуулсан байна.

Б.2.9 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд батлагдсан нийт төсөл, арга хэмжээнээс төсөвт байгууллагуудын урсгал зардал болон хөрөнгө бэлтгэх, зориулалт бус 120.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 арга хэмжээг төлөвлөж, баталсан байгаа нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан *“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”*-ын 3.5-д тусгагдсан заалтуудтай нийцэхгүй байна. Үүнд:

2021 онд:

- 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын маршрут, амралтын газруудын байршлыг харуулсан аппликейшныг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх”*,
- 25.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ажлын хэрэгцээнд автомашин авах”*.

2022 онд:

- 5.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“ИТМ аялал жуулчлалын үзэсгэлэн худалдаанд оролцох”*,
- 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Байгальд ээлтэй био жорлон байгуулах”*,
- 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Ажилтан, албан хаагчдын компьютерын техник болон программ хангамжийн хүчин чадал, хурдыг нэмэгдүүлэх, засвар үйлчилгээг хийх”*.

Б.2.10 Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс бүрдүүлсэн орлогоос хуулийн дагуу зарцуулбал зохих 16,784.9 сая төгрөгөөс 11.7 хувь буюу 1,958.3 сая төгрөгийг байгаль, орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан бөгөөд үүнээс зориулалт бусаар 119.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байгаа нь тус хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

³⁴ Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-4-Б маягтын дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор боловсруулна

Бүлэг В

Хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлсон эсэх

Шат, шатны ИТХ болон холбогдох бусад байгууллагаас Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт, шалгалт хангалтгүй байна.

В.1 Хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сан үнэн зөв илэрхийлэгдэж, төрийн байгууллагуудын уялдаа холбоо оновчтой байна уу?

Төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүйгээс БНАТ-ийн мэдээллүүд зөрүүтэй тайлагнагдсан байна.

В.1.1 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх “Мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлнэ” гэж заасны дагуу [eis.mn /finance/](http://eis.mn/finance/) гэх Байгаль, орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санг 2022 оноос ашиглалтад оруулан улсын хэмжээнд ашиглаж эхэлсэн байна.

В.1.2 2022 онд тус мэдээллийн санд аймгийн БОАЖГ-аас оруулсан мэдээллийг тулган шалгахад дараах мэдээллүүдийг зөрүүтэй мэдээлсэн байна.

Хүснэгт 11

Үзүүлэлт	БНАТ-ийн орлогын төлөвлөгөө	БНАТ-ын орлогын гүйцэтгэл	Давсан орлого	Нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлын төлөвлөгөө	Нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлын гүйцэтгэл
Аймаг, нийслэлийн БОАЖГ-аас eis.mn/finance/ системд оруулсан гүйцэтгэлийн мэдээгээр	4,780.4	10,882.3	6,101.9	2,418.6	1,403.5
Аудитаар	4,780.4	12,032.9	7,252.5	1,460.0	1,403.5
Мэдээллийн зөрүү	-	(1,150.6)	(1,150.6)	958.6	-

В.1.3 Тус мэдээллийн санд 2022 оны орлогын гүйцэтгэлийг 10,882.3 сая төгрөг гэж мэдээлсэн байгаа боловч аудитаар 12,032.9 сая төгрөгөөр тайлагнаж 1,150.6 сая төгрөгийн зөрүү үүссэн байна.

В.1.4 Дээрх хүснэгтээс харахад систем ашиглалтын байдал хангалтгүй, сумдын албан хаагчдад арга зүйн зөвлөгөө өгөөгүйгээс шалтгаалан 8 сум нь гүйцэтгэлийн мэдээ, тайланг зөрүүтэй илэрхийлсэн байна.

В.1.5 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т “Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 10 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн

төлбөр төлөгчийг бүртгэнэ” гэж заасны дагуу сумдын татварын байцаагчид 748 төлбөр төлөгчийг бүртгэн, төлбөр ногдуулалтыг тогтоосон байна.

В.1.6 Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралтын 4.6-д “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэл, сум, дүүргийн байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад жил бүр санхүүгийн дотоод аудит, хяналт-шинжилгээ хийнэ” гэж заасан боловч аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба болон бусад холбогдох газраас хяналт хийгдээгүй байна.

В.1.7 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга яам, агентлагтай доор дурдсан журмаар харилцана”, 72.1.1: “хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа яам, агентлагтай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах” гэж заасны дагуу жил бүр аймгийн БОАЖГ-аас ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний саналыг БОАЖЯ-нд албан бичгээр хүргүүлсэн байна.

В.1.8 Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс болон БОАЖГ-ын мэдээ тайлангийн харьцуулалтыг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 12

Төрөл	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл			Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын гүйцэтгэл	
	Аймаг, нийслэлийн санхүү, төрийн сангийн мэдээгээр орлогын гүйцэтгэлийн дүн	Татварын газрын мэдээгээр орлогын гүйцэтгэлийн дүн	Аймаг, нийслэлийн БОАЖГ-аас eic.mn/finance/ системд орлогын гүйцэтгэлийн мэдээг оруулсан дүн	Аймаг, нийслэлийн санхүү, төрийн сангийн зарцуулалтын гүйцэтгэлийн дүн	Аймаг, нийслэлийн БОАЖГ-аас eic.mn/finance/ системд зарцуулсан гүйцэтгэлийн мэдээг оруулсан дүн
Ойн нөөц	5,201.6	4,055.5	5,173.7	1,024.6	1,024.6
Ан амьтны нөөц	19.8	19.8	19.8	25.0	25.0
Усны нөөц	1,461.8	1,341.3	1,575.4	323.9	323.9
Ургамлын нөөц	2,875.8	4,087.5	4,113.4	30.0	30.0
Газрын нөөц	2,473.9	1,201.9	-	-	-
Нийт	12,032.9	10,706.0	10,882.3	1,403.5	1,403.5

В.1.9 Дээрхээс үзэхэд аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ нь Татварын хэлтсийн мэдээнээс 1,326.9 сая төгрөгөөр, БОАЖГ-ын мэдээнээс 1,150.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна.

В.1.10 Иймд БОАЖГ нь гүйцэтгэлийн мэдээ тайланг сум дундын Ойн анги, байгаль хамгаалагч, сумын татварын байцаагч, төрийн сангийн мэргэжилтнээр орлогын гүйцэтгэлийг баталгаажуулсны дараа Засаг дарга нараас албан бичгээр хүлээн авч, нэгтгэх хяналтын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

В.2 Хуулийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээг хийж үр дүнг дүгнэсэн үү?

Аймгийн ИТХ болон нийт сумдын 70.5 хувь нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт огт хийгээгүй байна.

В.2.1 БОАЖЯ-наас Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг Сэлэнгэ аймаг 2021 онд 6.0 хувьтай, 2022 онд 24.0 хувьтай хэрэгжүүлсэн гэж үнэлж, дүгнэсэн байна.

В.2.2 БОАЖС-аас аймгийн Засаг даргад 2022 онд 3 удаагийн албан бичгээр Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах мэдэгдэл болон чиглэлийг хүргүүлсэн байна.

В.2.3 Энэхүү мэдэгдэл, чиглэлийн дагуу аймгийн Засаг даргаас аймгийн БОАЖГ болон сумдын Засаг дарга нарт 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн “Мэдэгдэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах эдийн засгийн ангиллыг зөрчихгүй, зориулалт бусаар зарцуулахгүй байх, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах үүрэг чиглэлийг өгсөн байна.

В.2.4 Дээрх өгсөн үүрэг, чиглэлийн хүрээнд “2023 оны байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээ”-ний жагсаалтад тусгагдсан 1,664.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл, арга хэмжээг хууль, журмын шаардлагад нийцүүлэн, төлөвлөж аймгийн ИТХ-ын 2022 оны 86 дугаар тогтоолоор батлуулсан байна.

В.2.5 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд аймгийн ИТХ-аас хяналт, шалгалт хийгдээгүй бөгөөд 2021-2023 онд 5 сумын ИТХ нь ЗДТГ-ын холбогдох албан хаагчидтай хамтран сумын нутаг дэвсгэрт хяналт, шалгалтыг хийсэн байна.

Хүснэгт 13

Сумын нэр	Хяналт шалгалтын төрөл		Хяналт хийсэн чиглэл						Сумын ИТХ-аас хяналт хийсэн тоо			Аймгийн ИТХ-аас хяналт хийсэн тоо		
	Төлөвлө гөөт	Төлөвлө гөөт бус	Хууль тогтоомж	Ой	Урга мал	Ан амьтан	Ус	Газар	2021	2022	2023	2021	2022	2023
Ерөө сум	1	1	2	1			1		1	1				
Мандал сум	1							1		1				
Орхон сум	1		1	6		2		4	7	2	1			
Хүдэр сум	1	1	1	1	3		2	2	8	5	3			
Шаамар сум	1			1			1	1		2	1			

В.2.6 Уг хийгдсэн хяналт шалгалтаар дараах зөрчлүүд илэрч, Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ тооцуулахаар холбогдох мэргэжлийн болон хууль, хяналтын байгууллагуудад шилжүүлсэн байна. Үүнийг тодруулбал:

Ерөө сум:

- Ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй зарим ААН-үүд ус шүүж цэвэршүүлэх даланг ТЭЗҮ-ийн дагуу гүйцэтгээгүй.

Мандал сум:

- "Бороо гоулд ХХК"-ийн хүдэр тээвэрлэх замын ажил нь тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй,
- Мөн тус байгууллага нь тариалангийн газрын зориулалтыг өөрчлөн ашигласан,
- Хаягдлын даланг байгуулахад ашигласан материалын үнийг төлөөгүй, зөвшөөрөл аваагүй.

Орхон сум:

- Сумын нутаг дэвсгэрт газрын тухай хууль тогтоомж зөрчсөн 4, Ойн тухай хууль тогтоомж зөрчсөн 6, зөвшөөрөлгүй ан агнасан 2 зөрчил тус тус илэрсэн.

Хүдэр сум:

- Хориглогдсон газраас хадлан бэлтгэсэн, хадсан өвсийг бүрэн хамалгүй орхисноос түймрийн эрсдэл үүсгэсэн,
- Голын эх болон урсгалд бохир ус оруулсан, даланг сэтэлсэн.

Шаамар сум:

- Сумын худгууд орчны бохирдол ихтэй, хүн болон малын усалгааг хамт хийсэн.
- Аялал жуулчлалын чиглэлээр олгогдсон талбайн хэмжээг хэтрүүлсэн,
- Шаамар - Түшиг чиглэлийн автозамын гүйцэтгэгч нь ургаа мод унагаасан.

В.2.7 Дээрхээс үзэхэд аймгийн ИТХ болон нийт сумдын 70.5 хувь нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт огт хийгээгүй байгаа нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг бууруулж байна.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар илэрсэн нийт **4,946.8 сая** төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

- Аймгийн БОАЖГ-аас байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгуулахаар ирүүлсэн саналыг **4,802.9 сая** төгрөгөөр бууруулан өргөн мэдүүлж, батлуулсан,
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зориулалт бус **120.0 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан,
- Аймгийн Татварын хэлтэс нь Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7³⁵-д заасны дагуу Сав газрын захиргаанаас ус ашиглагч аж ахуйн нэгжүүдэд ногдуулсан усыг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласны болон

³⁵ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулах үндэслэлийг тодорхойлох;

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт

бохирдуулсны усны төлбөрийн **23.9 сая** төгрөгийн орлогын төсөвт төвлөрүүлээгүй, татварын өр үүсгэсэн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Сумдын төсвийн татварын орлогын дийлэнх хэсгийг буюу дунджаар 64.1 хувийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар зохицуулснаас сумдын суурь зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр хүрэлцэхгүй байх эрсдэлтэй байна.
- 2022 оны байдлаар аймгийн хөгжлийн бодлогын баримт бичигт дэвшүүлсэн “Ногоон хөгжил”-ийн зорилт, арга хэмжээний дунд хугацааны хэрэгжилт 99.3 хувьтай, богино хугацааны хэрэгжилт 92.5 хувьтай тайлагнагдсан байна.
- Аймгийн Засаг дарга нь өөрийн харьяа төсөв захирагч нарын 2021, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, хэрэгжилтийг үнэлж, дүгнэсэн байна.
- БНАТ-ийн орлогоос хуулийн дагуу зарцуулбал зохих доод хувь хэмжээгээр тооцож, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөж, батлаагүй байна.
- Зарим сумд “Ойн дагалт баялаг ашигласны төлбөрийн орлого”-ыг байгалийн ургамлын нөөц ашигласны орлогын дансанд төвлөрүүлсэн байна.
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хууль, журамд заасан хувь хэмжээгээр тооцон санхүүжүүлэхгүй байна.
- Шат, шатны ИТХ болон холбогдох бусад байгууллагаас Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт, шалгалт хангалтгүй байна.
- Төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүйгээс БНАТ-ийн мэдээллүүд зөрүүтэй тайлагнагдсан байна.
- Аймгийн ИТХ болон нийт сумдын 70.5 хувь нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт огт хийгээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Б.Нарантуяа-д:

- БНАТ-ийн орлогоос санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хууль, журамд нийцүүлэн батлах, зориулалтын бус арга хэмжээг төлөвлөж, батлахгүй байх.
- БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж, үр дүнг ИТХ-аар хэлэлцүүлж байх.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж-д:

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хуульд заасан хувь хэмжээгээр төлөвлөж, батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн мэдүүлж байх.
- Өмнөх оны давсан орлогоос дараа оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар гүйцэтгэх арга хэмжээг нэмж батлуулах саналыг аймгийн ИТХ-д өргөн мэдүүлж байх.
- БНАТ-ийн орлогоор хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль, журамд нийцүүлэх, зориулалтын бус арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэхгүй байх.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд үр нөлөө бүхий дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж, үр дүнг үнэлэх.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга П.Эрдэнэсайхан-д:

- Сум дундын Ойн ангиуд болон Хүдэр сумын "Ой анги" ОНӨААТҮГ -ын ойн дагалт баялаг хуш модны самрын эрхийн бичгийн орлогыг ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын дансанд төвлөрүүлж байх.
- Усыг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласны болон бохирдуулсны усны төлбөрийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлж байх.
- Хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сангийн үнэн зөв байдлыг хянаж байх.

Аймгийн БОАЖГ-ын дарга З.Түвшинтөгс-д

- Ойн нөхөрлөлүүдийн "Ойн менежментийн төлөвлөгөө"-г баталж, хэрэгжилтэд хяналт тавих.
- Мэдээллийн сан бүрдүүлэлтийн үнэн зөв байдалд хяналт хийж, мэдээллийг зөв оруулж байх.


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

С.БААСАНСҮРЭН

Ж.ЦОГТ

Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БОАЖГ-ААС ИРҮҮЛСЭН САНАЛ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,
Утас/Факс: (976)-7036-3653

2023.06.19 № 421
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.ЭНХТУЯА ТАНАА

Санал хүргүүлэх тухай


“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитаар илэрсэн зөрчил, дүгнэлт, зөвлөмжийн дагуу тодорхой ажил арга хэмжээ зохион байгуулж, 2024 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, зарцуулалтын төлөвлөлтөд анхаарч ажиллах болно.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

[Signature]

Г.ЦЭНГЭЛЗАЯА



**Аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай байгуулсан
хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн үнэлгээ**

№	Сумын нэрс	2021 он				2022 он			
		Нийт хэрэгжүүлсэн арга хэмжээний		Үүнээс: БНАТ, түүнтэй холбогдох харилцааг тусгасан арга хэмжээний		Нийт хэрэгжүүлсэн арга хэмжээний		Үүнээс: БНАТ, түүнтэй холбогдох харилцааг тусгасан арга хэмжээний	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Алтанбулаг	17	84.1	6	88.3	16	87.3	5	86.0
2	Баруунбүрэн	17	84.1	6	80.0	17	85.6	5	78.0
3	Баянгол	22	70.0	7	71.4	21	72.3	6	83.3
4	Ерөө	22	85.0	6	98.3	21	86.2	6	95.0
5	Жавхлант	15	74.0	6	73.3	16	90.0	5	94.0
6	Зүүнбүрэн	12	80.0	5	74.0	16	79.8	5	85.6
7	Мандал	22	88.2	6	88.0	21	86.6	5	84.0
8	Орхон	15	82.6	5	88.0	17	76.5	5	80.0
9	Орхонтуул	20	41.8	5	20.0	21	46.9	5	35.0
10	Сайхан	18	80.5	6	90.0	21	76.6	5	80.0
11	Сант	15	87.3	6	88.3	16	79.4	5	84.0
12	Сүхбаатар	12	83.3	5	79.4	16	88.1	5	84.0
13	Түшиг	15	82.0	5	76.0	16	61.9	5	42.0
14	Хушаат	15	92.0	5	98.0	16	90.0	5	92.0
15	Хүдэр	22	83.6	6	85.0	21	70.9	6	85.0
16	Цагааннуур	17	88.8	6	86.6	16	83.7	5	90.0
17	Шаамар	17	74.7	6	71.6	16	81.3	5	64.0
Нийт үнэлгээ		293	1362	97	1356.2	304	1343.1	88	1341.9
Дундаж үнэлгээ		17.2	80.1	5.7	79.8	17.8	79	5.2	78.9



Аймгийн Засаг дарга сум дундын Ойн ангийн дарга нартай байгуулсан
гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэсэн үнэлгээ

№	Аймгийн Засаг даргын харьяа сум дундын Ойн ангийн нэрс	2022 он			
		Хэрэгжүүлсэн арга хэмжээний		Үүнээс: БНАТ, түүнтэй холбогдох харилцааг тусгасан	
		Тоо	Үнэлгээний хувь	Тоо	Үнэлгээний хувь
1	Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн анги	14	91.5	5	92.3
2	Хараа бүсийн сум дундын Ойн анги	43	90.4	4	90.5
3	Бэлчир бүсийн сум дундын Ойн анги	16	88.1	8	91.5
4	Ерөө бүсийн сум дундын Ойн анги	40	86.7	7	88.5
5	Орхон бүсийн сум дундын Ойн анги	19	84.9	4	87.3
	Нийт үнэлгээ	132	441.6	28	450.1
	Дундаж үнэлгээ	26.4	88.3	5.6	90.0



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 20 өдөр


Дугаар А/13

Сүхбаатар сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг УАГ-ын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар, Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар болон аймгийн ИТХ-ын дарга (Б.Нарантуяа), Засаг дарга (Н.Лхагвадорж), Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Татварын хэлтсийн дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ, авч биелэлтийг тогтоосон хугацааны дотор ирүүлэхийг аймгийн ИТХ-ын дарга (Б.Нарантуяа), Засаг дарга (Н.Лхагвадорж), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (З.Түвшинтөгс), Татварын хэлтсийн дарга (Ц.Лхагвадорж) нарт зөвлөсүгэй.
4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор С.Баасансүрэн)-т үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Б.Батмөнх)-т даалгасугай.



Ч.ЭНХТУЯА